



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 111


Улаанбаатар хот

“Прогресс партнерс” ХХК-д
брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Прогресс партнерс” ХХК-д брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Прогресс партнерс” ХХК /Т.Туул/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН